



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2018 оны 04 сарын 16-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04-р сарын 16-ны өдрийн 15.00 цагт Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д болов.

2018 оны 04 сарын 16-ны өдрийн 14 цаг 30 минутад ХЭХ-ын дэгийн дагуу ҮЦТХТ-өөс 2018 оны 03-р сарын 28-ний өдрөөр тасалбар болгон гаргасан Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа”-нд үндэслэн хуралд оролцохоор хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэж бүртгэлийн ажиллагааг 15.10 минутад дуусав.

2018 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт саналын эрхтэй 1 446 755 ширхэг энгийн хувьцаанаас 931 632 ширхэг хувьцаа эзэмшдэг 8 хувьцаа эзэмшигч биеэр, 498 033 ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр оролцож компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 1 429 665 ширхэг хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцохоор бүртгүүлсэн нь компанийн “Дүрэм”-ийн 7.26 дугаар заалтад заасны дагуу “Компанийн саналын эрхтэй хувьцааны 65-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэснийг хангаж хурлын ирц 98,85 %-тай гарсан талаар хурлын ирцийн дүнг хурлын Тооллогын комиссын дарга Б. Лхамсүрэн хурлын даргад мэдээлж танилцуулав.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 03 сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу 2018 оны Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дашдондог овогтой Ганцэцэг удирдан зохион байгуулж явуулав.

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-аас гаргасан дүгнэлт
2. Техник импорт ХК-ийн 2017 оны ажлын тайлан
3. Техник импорт ХК-ийн 2018 оны ажлын төлөвлөгөө
4. Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, хороодыг сонгох.

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын

хорооны дарга, хараат бус гишүүн Ж. Баярсайхан, компаниас 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2018 оны ажлын төлөвлөгөө, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн талаар хурлын дарга Д.Ганцэцэг танилцуулав. /Хурлын материалд ТУЗ-ын дүгнэлт, тайлан, нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг хавсаргав./

Хурлын даргаас хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс тавьсан асуултуудад хариулж дууссаны дараа санал хураалтыг явуулав.

Хурлын тооллогын комиссоос 2018 оны 04-р сарын 16-ны өдрийн ХЭХ-аар

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. Компанийн 2017 оны ажлын тайлан
3. Компанийн 2018 оны ажлын төлөвлөгөө
4. ТУЗ-ын гишүүд, хороодыг сонгох

асуудлаар тус тус санал хураалт явуулж хэлэлцэх асуудлаар авах саналын хуудас, ТУЗ-ын гишүүдийг сонгох саналын хуудсуудыг тоолоход хуралд оролцсон нийт 10 хувьцаа эзэмшигчээс

1. Хэлэлцэх асуудал-1

Зөвшөөрсөн-9 Татгалзсан-1 Түдгэлзсэн-0

2. Хэлэлцэх асуудал-2

Зөвшөөрсөн-10, Татгалзсан-0 Түдгэлзсэн-0

3. Хэлэлцэх асуудал-3

Зөвшөөрсөн-10, Татгалзсан-0 Түдгэлзсэн-0

4. Хэлэлцэх асуудал-4

Зөвшөөрсөн-10, Татгалзсан-0, Түдгэлзсэн-0

дүнтэй санал өгөв. Хүчингүй хуудас гараагүй.

Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр санал хураалтын дүнг илтгэж хэлэлцэх асуудлаар 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудын төслийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Хурлын дарга Д.Ганцэцэг хурлыг хааж “2018 оны ХЭХ-аар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж саналаа өгсөн байна. Ингээд тогтоолын төслийг батлах шийдвэрийг өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж байна. Манай өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай болж өндөрлөлөө. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын амжилт, эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсье. Ирэх жил ХЭХ-даа дахин ирж идэвхтэй оролцохыг та бүгдээс хүсье. Ингээд 2018 оны Хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.” гэж хэлснээр хурлын ажиллагаа өндөрлөв.

Хурал 16 цаг 35 минутанд дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: *О. Бүжинлхам* О. Бүжинлхам

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ